



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2022 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 9/25

Номгон

**Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 40 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, акталж данснаас хасах журам”-ын 1.3, 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит IX хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 2021 онд ашиглалтанд орсон 33 600 000 (гучин гурван сая зургаан зуун мянган) төгрөгийн өртөгтэй УАЗ 22069 пургон авто машиныг Биеийн тамир, спортын газарт, Биеийн тамир, спортын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 2019 онд ашиглалтанд орсон 15 000 000 (арван таван сая) төгрөгийн өртөгтэй “Toyota prius-30” маркийн автомашиныг аймгийн Засаг даргын Тамгын газарт, Санхүүгийн хяналт аудитын албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2017 онд ашиглалтанд орсон 10 991 320 (арван сая есөн зуун ерэн нэг мянга гурван зуун хорин) төгрөгийн өртөгтэй LEXUS-470 маркийн автомашиныг Жинст сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд, Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн дансанд бүртгэлтэй 1975 онд ашиглалтанд орсон 71 684 154 (далан нэгэн сая зургаан зуун наян дөрвөн) төгрөгийн өртөгтэй хуучин сургуулийн барилгыг Баянлиг сумын Засаг даргын Тамгын газарт, Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2016 онд ашиглалтанд орсон 2 400 000 (хоёр сая дөрвөн зуун мянган) төгрөгийн өртөгтэй зөөврийн сагсны шийдийг Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуульд, Зооноз өвчин судлалын төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2009 онд ашиглалтад орсон 12,000,000 (арван хоёр сая) төгрөгийн өртөг бүхий 24-00 БНХ улсын дугаартай Mitsubishi Pajero маркийн автомашиныг Богд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тус тус балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Шилжүүлсэн хөрөнгийг тухайн байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны дарга, Биеийн тамир, спортын

0121160


газрын дарга, Баянлиг сумын Засаг даргын Тамгын газрын дарга, Ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт, шилжүүлэн авсан хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, холбогдох хууль журмын дагуу тухайн байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор бодит үнэ цэнэ, цаашид ашиглах жилийг тогтоож үндсэн хөрөнгөнд бүртгэхийг дээрх албан байгууллагын дарга, эрхлэгч, нягтлан бодогч нарт тус тус үүрэг болгосугай.

3.Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга (Ц.Идэрмөнх)-д дор дурдсан ажлыг зохион байгуулахыг даалгасугай.

3.1.Хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

3.2.Энэ тогтоолын хэрэгжилтийг 2022 оны 7 дугаар сард багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанд ирүүлэх.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Норов)-д даалгасугай.

ДАРГА  Э.ЭНХБАТ

